



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/318

Булган сум

### Химийн бодис, аюултай хог хаягдлын тооллого хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.3.6, 9.3.7 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөл батлах тухай” IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд аюултай хог хаягдал үүсгэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг гаргаж, тэдгээрээс гарч байгаа аюултай хог хаягдал, химийн бодисын тооллого хийж, ашиглалтын хугацаа дууссан химийн бодис, урвалж, электрон хаягдлыг татан авах ажлыг 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 12-ны хооронд зохион байгуулах удирдамжийг 1 дүгээр, замын маршрут, шаардагдах зардлын тооцоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх ажлыг зохион байгуулахад шаардагдах 8,024,732 (найман сая хорин дөрвөн мянга долоон зуун гучин хоёр) төгрөгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний “Химийн бодис, аюултай хог хаягдал үүсгэгчийн тооллого зохион байгуулах” төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Э.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг удирдамж төлөвлөгөөний дагуу чанарын өндөр түвшинд зохион байгуулж, химийн бодис, аюултай хог хаягдлыг аюулгүй тээвэрлэлт хийж, аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахад хадгалж, хяналт тавьж, холбогдох хэлтэст цаг хугацаанд тайлагнаж ажиллахыг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны  
05 дугаар сарын 15 -ний өдрийн  
А/318 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

Химийн бодис, аюултай хог хаягдал үүсгэгчийн тооллого хийж, хугацаа дууссан  
химийн бодис, урвалж, электрон хаягдал татан авах ажлын удирдамж

2025 оны 05 дугаар сарын 12

Булган сум

### **НЭГ.ЗОРИЛГО**

Аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/193 дугаар захирамжийн хүрээнд Булган аймгийн хэмжээнд аюултай хог хаягдал үүсгэгч, химийн хорт болон аюултай бодис хэрэглэгчдийн судалгаа, бүртгэлийг хийж, мэдээллийн сан бүрдүүлэхэд гол зорилго оршино.

### **ХОЁР.ТООЛЛОГЫН ТӨРӨЛ**

Аюултай хог хаягдал үүсгэгч, химийн хорт болон аюултай бодис хэрэглэгч аж ахуйн нэгж, иргэдийн бүртгэл, судалгааны ажлыг ажлын хэсгийн гишүүд газар дээр очиж бүртгэн, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажиллана.

### **ГУРАВ.ХАМРАХ ХҮРЭЭ**

Тооллогыг 16 сум, 1 тосгонд явуулах бөгөөд аюултай хог хаягдал үүсгэгч химийн хорт болон аюултай бодис хэрэглэдэг иргэн, аж ахуй нэгж, байгууллага хамрагдана.

### **ДӨРӨВ.БҮРЭЛДЭХҮҮН**

- 1.М.Хос-Эрдэнэ-Байгаль орчны газрын Орчны бохирдол хариуцсан Байгаль орчны хяналтын Улсын байцаагч,
- 2.Б.Оюун-Эрдэнэ-Байгаль орчны газрын Агаарын бохирдол, химийн хортой бодис, хог хаягдал хариуцсан мэргэжилтэн,
- 3.Жолооч
- 3.Сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч
- 4.Сумын холбогдох албан тушаалтнууд оролцоно.

### **ТАВ.ХУГАЦАА**

2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 12-ны хооронд ажлыг зохион байгуулна.

### **ЗУРГАА.ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ**

- 1.Аюултай хог хаягдал үүсгэгч, химийн хорт болон аюултай бодис хэрэглэдэг иргэн, аж ахуй нэгж, байгууллагын судалгаа, бүртгэл хийх;
- 2.Хугацаа дуусаж хадгалагдаж байгаа аюултай хог хаягдал болох химийн бодис, урвалжууд, зай хураагуурыг татан авах ажлыг зохион байгуулах;
- 3.Аюултай хог хаягдал үүсгэгчийн мэдээллийн сан үүсгэсэн байх;

### **ДОЛОО.ҮР ДҮН**

Аймгийн хэмжээнд байгаа аюултай хог хаягдал үүсгэгч химийн хорт болон аюултай бодис хэрэглэдэг иргэн, аж ахуй нэгж, байгууллагын судалгаа гаргаж, ашиглагдаж байгаа химийн хорт болон аюултай бодисын нэгдсэн дүнг гарган мэдээллийн санд бүртгэнэ. Мөн ашиглалтын хугацаа дууссан химийн бодис, урвалж, электрон хаягдлыг татан авч аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахад хадгалж болзошгүй эрсдэлээс хамгаална.

Аймгийн Засаг даргын 2025 оны  
05 дугаар сарын 15-ны/ний өдрийн  
А/318 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

ХИМИЙН БОДИС, АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ҮҮСГЭГЧИЙН  
ТООЛЛОГО, ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ЗАРДАЛ

Химийн бодис, аюултай хог хаягдал үүсгэгчийн тооллого хийх ажлын маршрут

| д/д | Сумын нэр            | Зай<br>/км/ | Д-түлш-<br>Норм /л/ | Шатахууны<br>хэмжээ /л/ | Нэгжийн<br>үнэ төг | Бүгд үнэ<br>/төг/ |
|-----|----------------------|-------------|---------------------|-------------------------|--------------------|-------------------|
| 1   | 2                    | 3           | 4                   | 5                       | 6                  | 7                 |
| 1   | Булган-Орхон         | 22          | 17                  | 3.74                    | 3950               |                   |
| 2   | Орхон-Бүрэгхангай    | 58          | 17                  | 9.86                    | 3950               |                   |
| 3   | Бүрэгхангай-Баяннуур | 100         | 17                  | 17                      | 3950               |                   |
| 4   | Баяннуур-Дашинчилэн  | 30          | 17                  | 5.1                     | 3950               |                   |
| 5   | Дашинчилэн-Рашаант   | 70          | 17                  | 11.9                    | 3950               |                   |
| 6   | Рашаант-Гурванбулаг  | 70          | 17                  | 11.9                    | 3950               |                   |
| 7   | Гурванбулаг-Могод    | 75          | 17                  | 12.75                   | 3950               |                   |
| 8   | Могод-Хишиг-Өндөр    | 63          | 17                  | 10.71                   | 3950               |                   |
| 9   | Хишиг-Өндөр-Булган   | 68          | 17                  | 11.56                   | 3950               |                   |
|     | <b>Дүн</b>           | <b>556</b>  |                     | <b>94.52</b>            | 3950               | <b>373,354</b>    |
| 10  | Булган -Сайхан       | 101         | 17                  | 17.17                   | 3950               |                   |
| 11  | Сайхан-Баян-Агт      | 72          | 17                  | 12.24                   | 3950               |                   |
| 12  | Баян-Агт-Хутаг-Өндөр | 80          | 17                  | 13.6                    | 3950               |                   |
| 13  | Хутаг-Өндөр-Тэшиг    | 103         | 17                  | 17.51                   | 3950               |                   |
| 14  | Тэшиг-Булган         | 246         | 17                  | 41.82                   | 3950               |                   |
|     | <b>Дүн</b>           | <b>602</b>  |                     | <b>102.34</b>           | 3950               | <b>404,243</b>    |
| 15  | Булган-Бугат         | 52          | 17                  | 9.3                     | 3950               |                   |
| 16  | Бугат-Сэлэнгэ        | 101         | 17                  | 18.0                    | 3950               |                   |
| 17  | Сэлэнгэ-Хялганат     | 45          | 17                  | 7.7                     | 3950               |                   |
| 18  | Хялганат-Хангал      | 40          | 17                  | 6.8                     | 3950               |                   |
| 19  | Хангал-Булган        | 114         | 17                  | 19.4                    | 3950               |                   |
|     | <b>Дүн</b>           | <b>359</b>  |                     | <b>61.3</b>             | 3950               | <b>242,135</b>    |
|     | <b>Нийт</b>          | <b>1643</b> |                     | <b>280</b>              | 3950               | <b>1,019,732</b>  |

ХИМИЙН БОДИС, АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ҮҮСГЭГЧИЙН  
ТООЛЛОГО, ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ЗАРДАЛ

| д/д | Зардлын төрөл                          | Хугацаа    | Хэмжих нэгж | Нэгжийн<br>зардал (төг) | Тоо<br>хэмжээ | Нийт /төг/       |
|-----|----------------------------------------|------------|-------------|-------------------------|---------------|------------------|
| 1   | 2                                      | 3          | 4           | 5                       | 6             | 7                |
| 1   | Томилолтын зардал                      | V/12-VI/12 | Хүн/ хоног  | 90,000                  | 3/25          | 6,750,000        |
| 2   | Шатахууны зардал<br>(ДТ)               |            | 17л/100км   | 3950                    | 280           | 1,019,732        |
| 3   | Гарын химийн бодис<br>авлага хэвлүүлэх | V/12       | ширхэг      | 300                     | 850           | 255,000          |
|     | <b>Дүн</b>                             |            |             |                         |               | <b>8,024,732</b> |